

Хүчний бодит тэнцвэрийг тогтоолгохоор ШХАБ, БРИКС-ийг нэг дор цуглуулна

Д.Баярхүү¹

Ердөө хэдхэн хоногийн дараа 2015 оны 7 дугаар сарын 7-10-нд дэлхий нийтийн анхаарал ОХУ-ын Бүгд Найрамдах Башкортостан Улсын засаг захиргааны төв Уфа хот руу төвлөрөх боллоо. Учир нь олон улсын хамтын нийгэмлэгт жинтэй байр эзэлдэг олон улсын ба бүс нутгийн хоёр том эвслийн (форум) дээд хэмжээний уулзалт бараг нэг дор цувран болох гэж байна. Олон улсын харилцааны түүхнээ тэр бүр тохиож байгаагүй энэ явдлын учир шалтгаан, түүний геополитикийн үр дагаврыг дор өгүүлбэ.

Нэг. Нөхвөр байх учир шалтгаан

Зургадугаар сард Германд G7-гийн дээд хэмжээний уулзалт явагдсан бол сарын дараа G5-ын дээд хэмжээний уулзалт болох гэж байна. Энд “G5” гэсэн нэр томъёог хэн ч гаргаагүй байгаа боловч уншигчдад ойлгомжтой болгох үүднээс би гаргачихлаа. Уг нь БРИКС (Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд Африк) гэж нэрлэж хэвшсэн л дээ. БРИКС-ийн 5 улсын Төрийн тэргүүний хоёр нь хасагдаад үлдэх гурав нь ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтад оролцоно.

Ийнхүү нэг дор цуглуулж, хоёр өөр эвслийн дээд хэмжээний уулзалтыг залгуулан явуулах ямар шаардлага даргалагч ОХУ-д буй болов гэх асуулт логикийн дагуу гарч ирнэ. Шалтаг шалтгаан тоочвол Оросоос зөндөөнийг эшлэж болно. Геополитик судалдагийн хувьд заримаас нь би тоочъё.

1. ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн зочин-профессор нийтлэлч. Энэхүү өгүүлэл дэх санаа дүгнэлтүүд нь зохиогчийн өмнөх Элчин сайдын албатай холбогдолгүй, Монгол Улсын ГХЯ-ны байр суурийг огтоос тусгаагүй болохыг анхаарна уу.

1. Гомдоно гомдоно, доромжлуулна доромжлуулна гэхэд үүнээс цааш тээсэхгүй гэсэн даргалагч улсын адгуу байр суурь эхний шалтгаан нь. G7-гоос хөөгдөж, G20-д ганцаардан шившиглүүлж байхыг Орос цааш тэвчихгүй.

2. Оросыг хөөж явуулчихаад буй G7 дэлхий дахины асуудлыг үр бүтээлтэй хэлэлцэж чадаагүй, чадахгүй гэдгийг Орос нотлох нь дараагийн шалтгаан.

3. Хүчний бодит тэнцвэр дэлхий дээр тогтоох өөр формат байдаг юм шүү гэдгийг дэлхий дахинд ойлгуулахыг Орос зорьж байгаа нь дахиад нэг шалтгаан.

4. БРИКС бол дэлхийн хүн амын 40 хувийн төлөөлөл, дэлхийн ДНБ-ий 20 хувийг үйлдвэрлэгч ба эзэгнэгч гэдгийг нотлох бас нэг шалтгаан.

5. ШХАБ бол Евразид, тодорхой хэлбэл Төв Еврази гэх асар том масштаб дээр өрнийнхний нөлөөний хүрээг тогтоолгохгүй байх бат бэх цул эвсэл шүү гэдгийг нотлох нь нэг чухал шалтгаан байж магад.

6. Эцэст нь их гүрнийх нь төрөлхийн араншин Оросыг ийнхүү хөдөлгөжээ гэж үзэж болно.

G7 дэлхий дахины асуудлыг үр бүтээлтэй хэлэлцэж чадаагүй, чадахгүй, хүчний бодит тэнцвэр дэлхий дээр тогтоох өөр формат байдгийг нотлон харуулах гэдэгт Ерөнхийлөгчийн хэвлэлийн албаны дарга Д.Песков онц ач холбогдол өгсөн мэдэгдэл хийжээ².

Уфад БРИКС, ШХАБ-ын хоёр уулзалт зохион байгуулах гэж буй нь Европт В.Путины явуулж буй өндөр өртөг бүхий үйл ажиллагааны нөхвөр юм гэсэн санааг өрнөдийн судлаачид бараг нэгэн дуугаар тэмдэглэж байна. Ялангуяа В.Путиныг Ерөнхийлөгч байх хугацаанд даян дэлхий дээрхи Оросын байр суурь хэр холбирч байгаад анализ хийсэн өгүүлэл, нийтлэл барууны сайтуудад олон байна.

Харвардын их сургуулийн “Хүйтэн дайн” судлалын хөтөлбөрийн захирал профессор Марк Крамер “Оросын тэнэглэл” гэх санаагаар

2. Вашингтонские споры о БРИКС, golos-ameriki.ru/content/us-about-brics/, 12.06.2015

ярилцлага өгч, бас судалгааны өгүүлээ хэвлүүлжээ³. Европ дахь бүх хөршөө, түүний дотор Беларусийг ч өөрийнхөө эсрэг босгож тэнэглэлээ. Оросын овилгогүй байр сууриас шалтгаалан олон жил төвийг сахиж явсан тэдгээр орнууд ч байр сууриа өөрчиллөө. Жишээ нь Финланд, Швед нь Оросын үйлдлээс болж НАТО-д нэгдэх тухай бодож эхэллээ. Оросын байр суурь Европт “Хүйтэн дайн”-аас хойшхи эрин үед хамгийн ихээр суларлаа. Өрнөд ертөнцийн нөгөө хэсэг – АНУ, Канадад Оросын байдал бүр хүнд байна. Оросын хувьд харилцаагаа гайгүй амжилттай авч яваа Ази ба Латин Америк гэж хоёр бүс нутаг байна, гэвч энэ бол Кремлийн ухаалаг бодлогын үр дүн биш. Дарангуйлагч хэлмэгдүүлэгч дэглэм бүхий Хятад, Иран, Хойд Солонгос зэрэг зарим түнш нь л Путины авторитари дэглэмийн ерөнхий байр суурийг дэмжих төдий байна гэжээ.

Хоёр. Үнэт зүйлсээ нэгтгэхүй

Хэрэв G7 эвслийг ажиг аваас бизнес, мөнгө, санхүү гэхээсээ илүүтэй нийтлэг үнэт зүйлсээрээ нэгдэж нягтарсан, хожим хэзээ ч эвдэрч салахгүй гэмээр төсөөлөл буудаг. G7 дээр СССР-ийг нэгтгэж, хожим ОХУ G8-ын нэг гишүүн болж явсан ч эдүгээ тэндээс хөөгдөн гараад буй нь Крымыг Орост нэгтгэснээс ч шууд үүдэлтэй бус, үнэт зүйлсээрээ Орос нь цаад 7-тойгоо нэгдэж нягтраагүй явсны балаг гэлтэй.

Тэгвэл эдүгээ Орос нь Хятадтай үнэт зүйлсээ нэгтгээд авсан уу гэвэл бас тийм биш байна. АНУ-тай аль алин нь өрсөлдөх хүсэл тэмүүллийг нь үнэт зүйлс гэдэггүй л юм бол харилцан талархахаар, нийтлэг нэгдсэн үнэт зүйлс гэх юм манай хоёр хөршид алга. Харин ч ашиг сонирхлын огтолцлын салбар, талбар олон байна. Америкийн жанжлалыг тогтоон барихын тулд тэд Иран, Венесуэл, Хойд Солонгосоос дэмжигч хайж явснаа одоо Энэтхэг, Бразил, Өмнөд Африк, мөн ШХАБ-ыг түшихийг энэ хоёр улс зорьж байж болох юм. Ялангуяа тийм сонирхол Оросын хувьд илэрхий ажиглагдана.

Америкийн гадаад бодлогын зөвлөлийн эксперт Стивен Бланкийн сонирхолтой судалгаа байна⁴. Бүслэлтийн менталитет гэх өвчин

3. Why Russia Intervenes, perspectives.carnegie.org/May 2015

4. Stephen Blank. Putin's next offensive, washingtontimes.com/news/2015/apr/9/

Оросыг ороогоод байгаа ба Кремлийнхний алдаатай гадаад бодлого нь Оросын дотоод байдлыг бужигнуулж, орос хүмүүсийн аж байдлыг доройтуулж, нийгмийн хөгжлийг нь чөдөрлөж байгаа ажээ. Энэ бүхний буруутан нь Путин, КГБ-гээс гаралтай түүний хуучин офицеруудын бүлэг хэмээн эрдэмтэн Бланк нэрлэжээ. Тэд бол дайсагнагч капиталист хүрээлэлд бүслэгдсэн, Оросоос бусад ертөнцтэй үргэлжлэн дайны байдалд оршиж байх ёстой гэсэн сэтгэхүйтэй.

Хэрэв СССР-ийн үеийн гадаад бодлоготой нь харьцуулж үзвэл ОХУ-ын өнөөгийн гадаад бодлого нь түүний ойрын хөршүүдэд халгаатай, Зөвлөлт Холбоот Улс нь сайн хөршийн харилцааны концепц баримтлаад, найрамдал, үзэл суртлынхаа нийтлэгээр холбогдож, ухаалаг дипломат бодлого явуулж байсан бол эдүгээ Кремлиэс Гүрж, Украины эсрэг явуулж буй түрэмгий бодлогын уршгаар сайн хөршийн харилцааны концепц нь алдагдаж завхарсан. Одоо Орос нь бусад хөршүүддээ хяналт тавихын төлөө л ажиллаж байна. Энэ утгаар Орос бол хамгийн тааруухан хөрш хэмээн Бланк тэмдэглэжээ.

Нэгэнтээ эргэн тойрон дайсантай байна гэж үзвэл, тэр томъёоллоор оросын нийгэм байнгын харанга түгшүүрийн дор, дайчилгааны байнгын бэлэн байдалд, эдийн засаг нь улам бүр милитаричлагдаж, хүмүүс нь сайхан амьдрахаасаа эмээж, тэр утгаар нийгэм нь огтоос хөгжилгүй болдог аж.

Стивен Бланкийн үзэл бодлыг авах гээхийн ухаанаар хүлээн авууштай. Гэхдээ анхаарах зүйл байна. Бүслэгдсэн цайзын тухай үнэт зүйлс гэдгийг тэрээр гаргаж тавьсан байна. Тийм үнэт зүйлсээр хэнтэй холбогдож, хэнтэй хоршиж, хамтран ажиллах вэ?

Гурав. БРИК-ээс БРИКС

БРИКС нь ӨАБНУ-ыг 2011 онд өөртөө нэгтгээд даялал чиглэлээ Африк руу сунгачихлаа. Дэлхийн Банкийг (төв байр нь Вашингтонд) сөргүүлсэн БРИКС-ийн хөгжлийн шинэ банк гэдгийг 10 тэрбум ам.долларын хөрөнгөтэйгээр Шанхайд төвлөрүүлэн энэтхэг хүнээр даргалуулан байгууллаа. Өөрөөр БРИКС нь G7-г сөрөхөөр ямар ч алхам хийсэнгүй. Дээд хэмжээнд уулздаг, яриа уулзалтын элдэв механизм сэддэгээс өөрөөр өрнөдийг сөрсөн үйл ажиллагаа явуулаагүй байна.

БРИК-ийг анхлан хөгжиж буй эдийн засгуудын холбоо маягаар байгуулснаас бус G7-той өрсөлдүүлэхээр гаргаж ирээгүй хэмээн Оросын Сангийн дэд сайд асан эдийн засагч Сергей Алексашенко үзэж байна. Хамтын ажиллагааны асар том төлөвлөгөө ярилцаж баталсан ч, хэрэгжүүлдэг механизмаа боловсруулж чадаагүй, ихэнхи шийдвэр нь уриа тунхагийн шинжтэй явсаар өнөө хүрсэн. Олон улсын форум, G20-ийн уулзалт дээр БРИКС-ийн орнууд хамтарсан мэдэгдэл хийж байсангүй, шийдвэрээ консенсусаар гаргадаг учраас маргадаг зөрдөг асуудал ч гэж өвөр хооронд нь гарч ирдэггүй. БРИКС-ийн гурван гишүүн нь АНУ давамгайлсан монополяр (ганц туйлт) ертөнцийг таалдаггүй. Цөмийн хүчирхэг гүрний хувьд Орос нь Америктай цэргийн хүч чадавхи тэнцүү байхыг зорьдог, эдийн засгийн хөгжлөөр Хятад нь АНУ-тай тэгш эрхтэй байхыг зорьдог, харин Бразил нь үнэмлэхүй бие даасан бодлого явуулахыг зорьдог. Үүнийг нь л үнэт зүйлс гэхгүй бол өөр юу эднийг нэгтгэж байна вэ⁵ гэх санаагаар оросын эдийн засагч бичжээ.

Оросын улс төрийн бодлогын уламжлал гэж байна. Тэр нь ихээхэн туйлшрамтгай. Нэг бол хэн нэгний төлөө “За”, нэг бол “Үгүй” гэж байхаас бус дундын хувилбарыг огтоос үл хэрэгсэнэ. Тэр утгаар БРИКС-ийг ч, ШХАБ-ыг ч АНУ, түүний өрнөд дэх холбоотнуудын эсрэг “Үгүй” гэж хэлүүлэхийг л Орос зорьж ирсэн мэт.

БРИКС, ШХАБ, шинээр төлөвшиж буй Евразийн эдийн засгийн холбооны (ЕАЭС) аль алинд улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны тунхаглал олон бий. БРИКС нь шинэ банк байгуулж байгаа, өвөр хоорондоо хэрэглэх дотоодын нэг валюттай болох тухай зарласан, тэр нь долларын эсрэг валют байх болно гэснээс өөрөөр БРИКС-ийн гишүүдийн хооронд эдийн засгийн харилцаа огтоос алга. Хятадтай хийж байгаа худалдааных нь үзүүлэлтээс үзвэл глобал эдийн засагт Хятадын оролцоо л өсч байх шиг.

МГИМО-гийн (Москвагийн ОУХДС) профессор, БРИКС-ийн судалгааны үндэсний хорооны захирал Георгий Толорая гэдэг эрдэмтний үзэж байгаагаар БРИКС бол эвсэл биш, дэлхийн томхон эдийн засаг

5. Задайте вопрос Сергею Алексашенко! echo.msk.ru/guests/293/

юм байна⁶. Тэгэхдээ энэ байгууллага үр ашигтай байгаа эсэхийг эдийн засгийн үзүүлэлтээр ярих ёсгүй, ерөөсөө дэлхийн удирдах тогтолцоог шинэчлэхийн тулд БРИКС-ийг гаргаж ирсэн ба санхүүгийн глобал тогтолцоог шинэчлэх хүсэлтэй реформист орнуудаас энэ эвсэл бүрдэж байна. Тэгэхдээ эдийн засгийн холбоо бас биш. АНУ-ын эсрэг ч чиглээгүй хэмээн тэрээр тэмлэглэжээ. Олон иргэншил, соёлтой орнуудыг нэтгэж буй БРИКС нь орчин үеийн “хэрэглээний нийгэм”-ийг сэргүүлсэн нийгэм-эдийн засгийн шинэ загвар хэтдээ болох ёстой аж. Шинэ загвар нь өөртөө экологи, хүний аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, ногоон эдийн засаг, соёлын ба хүмүүнлэгийн тусламжийг бүгдийг багтаасан байх ба энэ байгууллага нь хэзээ ч цэргийн эвсэл болохгүй хэмээн Толорая үзэж байна.

Дөрөв. Умард-Өмнөдийг зэрэг төлөөлжээ

БРИКС гэх энэ бүлэгт ОХУ нь уламжлалт аж үйлдвэржсэн “Умард”, бусад нь ялангуяа Энэтхэг, Өмнөд Африк нь “Өмнөд”-ийг төлөөлдөг, тэр утгаар БРИКС-ийн өмнөд эвслийн гишүүд нь “Умард”-ыг сөрж зогсохыг уриалсан нь бий. Аж үйлдвэрийн хавсарга, түүхий эдийн зах зээл, хямд ажиллах хүчин байхыг тэд эсэргүүцдэг. “Умард”-тай гарааны нөхцөл адил байхыг тэд шаарддаг. Хэрэв нарийвчлан авч үзэн харьцуулалт хийх аваад Энэтхэг, Хятад хоёр нь эдийн засаг, глобал өрсөлдөөн, хөгжлийн асуудлаар нийтлэг гэхээсээ зөрүүтэй байр суурь тус тусдаа баримтлаж байх шиг.

Улс төр-эдийн засгийн асуудал шийдэх арга барилын хувьд өрнөдийн тал баримтлан, тэдний аргачлалыг нэвтрүүлэхийг хүсэгчид Орост өөрт нь олон байна. Гэтэл тэдний тэр даяаршлын либерал загварыг үл хүсэгчид нөгөө орнуудад олноороо шийдвэр гаргах хэмжээнд байна. Өрнөдийн тэргүүний соёл ба иргэншилд буулт хийж, онцлог мөн чанараа өрнөдтэй дөхүүлэхийг Орост сэхээтнүүдийн олонхи үздэг бол түүнтэй үл эвлэрэгчид Хятад ба Энэтхэг, цаашлаад Өмнөд Африкт өдий төдийгөөрөө байх жишээтэй. Орос тэгж өрнөжихгүйгээр эрчтэй хөгжиж буй Хятад, Бразилын бизнесийн хөлд сөхөрчих вий гэх болгоомжлол байгааг буруутгах аргагүй. Тэгээд ч глобал сэргөлдөөн

6. Зачем России БРИКС? globalaffairs.ru/number/ 19 февраля 2015

өрсөлдөөнд өрнөдийн арга барил, тэргүүн туршлагагүйгээр оролцох аргагүй гэдэг нь ойлгомжтой.

Нэгэнт л өрсөлдөөн сөргөлдөөн дунд өрнөдийн эвслийг сөргүүлж, дэлхийг дахин хуваах үйл явцад авангард болохоор гарч ирж байгаа учраас БРИКС нь геоэдийн засгийн гэхээсээ геополитикийн бүлэглэл болон төлөвшиж байгааг бид харж байна. Гэхдээ гишүүн орнууд нь улс төрийн нэн харилцан адилгүй тогтолцоотой, хөгжлийн ба эдийн засгийн загварууд нь харилцан адилгүй, иргэншил соёлын хувьд харьяалал нь өөр өөр байгаа нь түүний нэг гол онцлог. Тийм учраас Европын Холбоо, НАТО шиг унификацिलाх боломж хэзээ ч бий болохгүй.

Тав. НҮБ, Бреттон-Вудс хуучирсан гэх онол

Дэлхийн II дайнаас хойш олон улсын харилцаанд удирдлагын глобал механизм болж ирсэн тэр тогтолцоо (НҮБ, ГАТТ ба ДХБ, Дэлхийн Банк, ОУВС) үл нөлөөгөө алдлаа, санхүүгийн капитал ба зах зээлийн фундаментализмд суурилсан глобал эдийн засгийн загвар хүчгүйгэж эхэллээ гэх онолыг Орос ба БРИКС-ийн зарим орнуудад ихээхэн ярих болжээ. Орос ч өөрөө Крымын асуудлаар НҮБ-д санал хураалгах үед үүнийг нотлуулчихсан. Хөгжиж буй орнуудад жанжлалын эсрэг үзэл санаа хүчтэй хэвээр байна. Гэхдээ өрнөдийг сөрж чадах хүчин зүйл нь мөхсдөх аж. Технологийн ба нийгмийн хоцрогдол гэх зүйл араас нь чангаагаастай.

Олон улсын аюулгүй байдал ч олон хувилбартай өрнөж байна. Эвсэл бүлгийн нэгдмэл байр суурь, хоёрдмол ацалсан стандарт, бүс нутагчлал, салбар дэд бүс нутагчлал гээд олон үйл явцыг бид туулж байна.

Дэлхий дахинд хүчний харьцаа, хүчний төвүүдийн өөр хоорондын тэнцвэрт хувилбар гарч байна. Гэхдээ АНУ төвтэй өрнөдийн эвслийг сөрөн зогсох, хүчгүйтүүлэх өөр боломжийн хувилбар одоогоор алга.

Гэхдээ даяаршил гэх үзэгдэл өрнөсөн, газар авсан учраас түүнийг нь дагалдан БРИКС нь олон төрөл янзын төлөөлөлтэй үүссэн байж болох юм хэмээн оросын эрдэмтэн Андрей Виноградов үзэж байна⁷.

7. Государственно-политические «коды» востока и запада, intertrends.ru/ Том 13, № 1, 2015

Хэдийгээр тэд нийгэм-эдийн засгийн харилцан адилгүй загвартай, иргэншлийн хувьд янз бүр байгаа ч тэднийг даяаршил нэг цэг дээр уулзуулж, олон улсын харилцааны гол субъект болгочихлоо. Гэхдээ БРИКС бол өрнөдийг сөрөн эсрэгцэхгүй юм. Умард Атлантын үнэт зүйлс, амьдралын хэв маягийг БРИКС-ийн бүх гишүүн орнууд хүндэтгэх боловч тэр нь санхүү-эдийн засгийн архитектурыг авч явах цорын ганц зөв арга гэж үзэхгүй. Өрнөд гэдэг бол технологи, хөрөнгө оруулалт, борлуултын нэг үндсэн эх үүсвэр мөн бөгөөд зарчмын хувьд үүнийг чухалд үзнэ.

БРИКС дотроо Хятад нь онцгой үүрэгтэй болж ирж байна. Учир нь глобал бүх эдийн засаг Хятадтай холбогдож байна. Тэр утгаар БРИКС дотроо эдийн засгийн том хүч юм. Өрнөдийнхөнд ганц талын ашиг өгдөг тэр санхүү-эдийн засгийн глобал тогтолцоонд өөрчлөн байгуулалт хийх нь Хятадад ашигтай тусна. Хятад нь XXI зууны дунд үе гэхэд баян, хүчирхэг, ардчилсан, иргэншсэн, эвсэн зохицсон, орчин үеийн социалист улс болох нь БРИКС-т ашигтай, дэлхийн эдийн засгийн гүрэн болох тэр хүсэл тэмүүллийг нь БРИКС-ийн бусад гишүүд дэмжинэ, харин улс төрийн хувьд манлайлах гэвэл дэмжихгүй хэмээн А.Виноградов төсөөлж байна.

Энэ утгаар бол БРИКС-т Бээжингийн үүрэг роль эрс өсөх бололтой юм. Гишүүн 5 улс нь ашиг сонирхлоо зөв огтолцуулж, тэр нь өргөжиж байвал болох аж. Энэ 5 улс 5-уулаа дэлхийн тавцан дээрхи тоглоомын одоогийн дүрэмд таагүй хандаж, түүнийг өөрчлөхийн төлөө зогсож байгаа нь нэн чухал юм. Олон улсын хуулийн дагуу тоглохыг илүүтэйд үзнэ. НАТО-гийн тухайд БРИКС түүнтэй сөргөлдөхгүй, өөрөө цэргийн эсвэл болохгүй. НАТО-гийн үндэс нь АНУ-ын хатуу шахалт хавчилт байдаг бол БРИКС-ийнх эрх тэгш улсуудын яриа хэлэлцээний формат нь зарчим нь болж байдгаараа ялгаатай гэнэ. БРИКС нь бүх улс орнуудын эрх ашгийг зэрэг харгалзсан хүчний тийм шударга харьцааг даян дэлхийд тогтооход туслах үүрэгтэй хэмээн үзэцгээж байгаа ба тэр нь НҮБ, түүний механизм хүчгүйтлээ гэсэнтэй адил утгатай юм. Олон улсын валют-санхүүгийн загварыг өөрчлөн шинэчлье, олон улсын тогтвортой, урьдчилан тооцоолж болохуйц нөөц валютын тогтолцоо буй болгоё хэмээн уриалан дуудаж байгаагаар бол ОУВС,

Дэлхийн Банкныг үгүйсгэж байгаа мэт сэтгэгдэл төрөхөөр юм. Гэтэл үгүй ч юм шиг. БРИКС-ийн хөгжлийн банк нь глобал санхүүгийн институт, бүтэцтэй өрсөлдөхөд зориулагдаагүй, түүнийг орлох гэж байгуулаагүй, харин түүнд нэмэр болгох гэж байгуулсан хэмээн В.Путин Петербургийн олон улсын эдийн засгийн форум дээр гэнэт мэдэгдэв. БРИКС-ийн бүх гишүүн орон ОУВС, Дэлхийн Банктай сайн харилцаатай байна. Орос болон БРИКС-ийн орнуудын хөгжилд нь туслах гэж ОУВС, Дэлхийн Банк сонирхлоо илэрхийлж байна хэмээн Оросын Төрийн тэргүүн хэлэв⁸.

Үнэндээ ч В.Путин нөхцөл байдлыг бодитой олж харсан мэт. *Bloomberg* агентлагаас “Дэлхийн хамгийн муу эдийн засаг-2015” рейтингийн судалгаа гаргасныг оросын эдийн засагчид эрхбиш төрдөө уламжилсан байх. Уг судалгаагаар эдийн засгийн муу үзүүлэлтээр Украин, Орос хоёр сүүл барьжээ. 2015 оны 4 дүгээр улирал гэхэд Оросын ДНБ 2014 оны мөн үеийнхээс 3.5 хувиар унасан байх юм байна. БРИКС-ийн гишүүн Бразилын эдийн засаг -1.6 хувийн үзүүлэлттэй, харин ДНБ хамгийн хурдан өсөлттэй гэдгээр Энэтхэг 7.5 хувь, Хятад 6.9 хувиар бичигджээ⁹. Эндээс үзвэл БРИКС маань эдийн засаг, санхүүгийн чадавхиар алаг цоог байх бололтой.

Зургаа. Ойрын зорилт, эсвэл Оросын ятгалга

Дээр бичсэнээс үзвэл БРИКС нь барьцтай тоймтой механизмгүй, онож дүрслэхэд түвэгтэй олон улсын нэгэн бүтэц мэт. Тэгэхлээр ойрын зорилт нь харилцан ажиллагаагаа боловсронгуй болгох, зохион байгуулалтын үндсээ төлөвшүүлэх, глобал тавцанд байр сууриа бэхжүүлэх явдал болж таарах нээ. Албан бус яриа хэлэлцээний форум байгааг байр сууриа харилцан зохицуулдаг, стратегийн харилцан ажиллагаа бүхий бүрэн формат бүхий механизм болгох нь чухал хэмээн оросын тал үзэж байна. Тэгсэн цагт БРИКС нь олон улсын харилцаанд хүндтэй байраа эзлэх аж¹⁰.

8. Путин рассказал о сотрудничестве БРИКС с глобальными финансовыми институтами, lenta.ru/2015/06/20

9. The 15 Most Miserable Economies in the World, bloomberg.com/2015-03-02/

10. Зачем России БРИКС? globalaffairs.ru/number/ 19 февраля 2015

Яг ийм төслийг ОХУ бусад гишүүддээ санал болгож байна. Энэ санал хэрэгжих аваас нийгэм-эдийн засгийн шинэ глобал стратегид БРИКС нь инкубатор болж хувирах аж. Улмаар хүн төрөлхтөний өнөөгийн хөгжлийн альтернатив загвар болж төлөвшинө. Тулхтай хөгжлийн шинэ парадигм нь оросуудын санал болгож буй тэр БРИКС байх ажээ.

ОХУ-ын зүгээс ийнхүү ирээдүйгээ тодорхойлохдоо БРИКС-ийн гишүүдээ илэрхий уриалан дуудсан, шахсан ятгасан, адгасан байдал нь харагдаж байна¹¹. Яг ийм уриалгын дор ОХУ нь БРИКС-ийг даргалагч улсын үүргийг 2015 оны 4 дүгээр сард авчээ. Ингээд БРИКС, ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтыг нэг дор Уфа хотноо явуулах шийдвэр гаргажээ. Уфа нь Оросын Азийн хэсэгт хамаарах тул Азид энэ хоёр саммит явагдана гэсэн үг. Тэр утгаар хоёр саммит дээр Хятад руу хандуулсан Оросын бодлого илүүтэй цухалзах болов уу хэмээн судлаачид таамаглаж байна.

Энэ удаа ОХУ нь БРИКС, ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтыг нэгэн зэрэг, нэг газар хамтатган хийж байгаагаараа хоёр байгууллагын түүхэнд онцгойд тооцогдох үйл явдлыг эхлүүлж байна. Украины хямралаас шалтгаалан ОХУ нь Европ, өрнөдийн ертөнцөд бүрэн ганцаардсан тохиолдолд энэ хоёр саммитыг явуулах эрхийг авсан ба тэр эрхээ онцгой давуу эрх болгон геополитикийн зэвсэгтээ ашиглаж таарах нь байна. ХХI зуунд Орос нь геополитикийн сэргэн мандалтдаа БРИКС-ийг локомотив болгон ашиглаж, ШХАБ-аар түүнд хүч нэмнэ¹² гэсэн санааг профессор Георгий Толорая гаргаж тавьсан нь анхаарал татлаа.

Тэр ч бүү хэл, БРИКС-ийг локомотив болгон ашиглахаа хууль ёсны, жам ёсны гэж үзжээ. Өрнөдтэй харилцаа эрс муудсан, тэгэхлээр ганцаардахгүйн тул ингэхээс өөр арга байхгүй. Хэрэв өрнөдтэй ганцаараа тулалдвал ялагдал нуралт гарцаагүй, тэгэхлээр ялагдал нуралтаас гэтэлгэхэд БРИКС-ийн бусад гишүүн орнууд Орост тусална.

Орос-Хятад-Энэтхэгийн стратегийн гурвалжингийн тухай үзэл санааг тухайн цагтаа ОХУ-ын Ерөнхий сайд Евгений Примаков

11. Мөн тэндээс үзэж болно

12. Мөн тэнд

дэвшүүлсэн нь яван явсаар БРИКС-т хүргэсэн ба хамгийн чухал нь Орос дорно зүгтээ найдвартай ар талтай болсонд Оросын төр засаг академич Е.Примаковт талархаж бардаггүй бололтой.

Долоо. Алаг цоог БРИКС

Америкийн шинжээч Кеннет Рапоза *Forbes* сэтгүүлд БРИКС-ийн талаар сондгой өнцгөөс харж сонирхолтой санаа дэвшүүлжээ. Энэ эвслийн маргаангүй лидер нь эдийн засгийн хэт их гүрэн болчихсон Хятад юм. Хятад л алаг цоог оролцогчдыг нь оройлж магадгүй аж. Алаг цоог оролцогч бүхий БРИКС олон улсын талбарт өөрийгөө хэн болохыг нотлох нь энэ залуу байгууллагын зорилт хэмээн тэрээр бичсэн байх юм. Орос бол БРИКС-ийн хамгийн “улс төржсөн” оролцогч, Энэтхэг бол хүн амынхаа тоогоор “хамгийн том ардчилал”, Энэтхэгийг тэр үзүүлэлт нь алдаршуулдаг. БРИКС байгуулагдсанаас хойш улс орнуудын нэрийн эхний үсгийг нийлүүлж нэрлэсэн холбоо байгуулдаг моод дэлгэрсэн, жишээ нь ПИГС буюу Португал Ирланд, Итали, Грек, Испанийг оролцуулсан Баруун Европын байгууллага байна. Гэхдээ л G7-гийн нэр хүнд хүчтэй хэвээр байна. Нэр хүнд нь уналаа хэмээн Оросоор өөр нэрлэж байгаа улс алга хэмээн К.Рапоза бичжээ¹³.

ШХАБ ба БРИКС нь өрнөдийнхөн рүү чиглэсэн альтернатив хувилбар байж болно. Орос-Хятад-Энэтхэг гурав эвсэн нэгдэж чадвал Азид хамтын аюулгүй байдлын ирээдүйн өвөрмөц систем буй болгож болно¹⁴ гэх санааг 2014 оны намар ШХАБ-ын Душанбейн саммитын үеэр оросын *Русская весна* портал сайтад бичсэн байсныг санаж байна. Хэрэв энэ хүчийг нийлүүлж чадвал НАТО-гоос хавьгүй давуутай, хүчирхэг цэргийн эвсэл бий болно хэмээн тэнд бичсэн байв. Харин энэ санааг өлгөж аван барууны сайтуудад энэ нь Кремлийн мөрөөдөл, эсвэл далд төлөвлөгөө хэмээн хардсан байв. “Нийтийн дайсан”-ы эсрэг их хүчийг ашиглах, босгох гэдэг бол Оросын “Бүслэлтийн менталитет”-ийн ужиг өвчнөөс үүдэлтэй, харин Оросын энэ хүслийг Хятад, Энэтхэг, ШХАБ-ын бусад гишүүд даан ч дэмжихгүй болов

13. Kenneth Rapoza. Russia Wants To Convince BRIC Partners To Create Alternative Banking System, forbes.com/sites/kenrapoza/2015/06/01/

14. Душанбинский саммит ШОС, как "декларация намерений в адрес США и НАТО", nakanune.ru/service/

уу хэмээн барууныхан үздэг аж. Харин БРИКС ба ШХАБ нь эдийн засгийн интеграцын чиглэлээр цаашид эргэлтгүй төлөвшбөл хүч нөлөөгөөрөө Хятад давамгайлах тул ОХУ өөрөө дэмжихгүй. Тэгэхлээр БРИКС, ШХАБ-ыг цааш хэрхэх вэ гэдэг дээр Орос, Хятадын байр суурь нэгдмэл биш байх шиг харагдана.

Алаг цоог байхаас гадна Орос өөрөө оролцож, уриалж, оройлж буй болгосон эвсэл холбоод нь ТУХН одоо юу ч биш болчихоод байгаа шиг хувь тавилантай учирна хэмээн хэт өөдрөг бусаар үзэх шинжээчид бас байна. Азербайжаны **Trend порталд эрдэмтэн** Мубариз Ахмедоглы ярилцлага өгөхдөө тэгж тарж бутардаг, ажиллахаа больдог механизмаар Евразийн эдийн засгийн холбоог нэрлэжээ¹⁵. Ер нь аливаа эвсэл холбоо байгуулагдмагц Орос манлайлах үүргийг өөртөө авдагаас тэгж дампуурах үндэс болдог гэсэн нь ШХАБ, БРИКС-ийг нэрлээгүй ч холуур яригдах хөндлөнгийн сэдэв бас биш ээ. Тэгэх тусмаа Уфагийн саммитын босгон дээр тэгж анхааруулсан байна. Тухайлбал Арменыг хүчлэн байж, Беларусь, Казахстаны байр суурийг үл харгалзан Евразийн эдийн засгийн холбоондоо татан оруулсан нь энэ холбоо цаашдаа ажиллахгүй болох нэг шалтгаан байж болно хэмээн тэрээр үзжээ. Түүний үзэж байгаагаар, Орос оролцсон олон улсын, бүс нутгийн аливаа байгууллагад цаад оролцогчид нь Оросын эсрэг ямагт хоёр нүүрт бодлого явуулдаг болчихдог аж.

Найм. Уфад хэрхэн уулзах вэ?

ОХУ-ын Башкир дахь Кушнаренковскийн районд ШХАБ, БРИКС-ийн нийслэлүүд хүртлэх холын зайг тодорхойлсон томхон баганыг босгожээ. Түүн дээр Орос, Хятад, Казахстан, Тажикистан, Кыргызстан, Узбекистан, Бразил, Энэтхэг, ӨАБНУ-ын нэрсийг сийлжээ. Нийт 9 улсын нэрс байна. Бэлгэдэлийн энэ багана дээр Энэтхэгийн нэр байгаа нь энэ улс ШХАБ-д жинхэлж болохыг илтгэсэн мэт. Нэгэнтээ БРИКС-т хамт байгаа, үндэслэгч нь Орос-Хятад-Энэтхэгийн гурвалжингийн бодлогодоо суурилад ШХАБ-д элсэхийг үгүйсгэхгүй.

15. Фахраддин Абосзода. Азербайджанская пропаганда: «Баку выбирает Европу», [regnum.ru/news/polit/12 июня 2015](http://regnum.ru/news/polit/12_июня_2015)

Нөгөө талаас 2014 онд Душанбейн уулзалт дээр Владимир Путин ШХАБ-ыг ирэх онд (2015 оныг хэлсэн хэрэг) өргөжүүлж болохыг тэмдэглэчихсэн. Оросын уламжлалт түнш Энэтхэг, Хятадын уламжлалт түнш Пакистан хоёр зэрэгцээд ШХАБ-ын хаалгыг татна гэх таамаг гадаадын сайтуудад цөөнгүй явж байна.

Уфад бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар нухацтай яриа өрнүүлнэ, ШХАБ-ыг Орос, Беларусь, Казахстаны Гаалийн Холбоо буюу Евразийн эдийн засгийн холбоотой ажил төрлийг нь уялдуулах, хамтын ажиллагааг нь өргөжүүлэх талаар ярилцана хэмээн Путин өөрөө зарласан. ШХАБ ба ЕАЭС-ээс НҮБ-тай тогтоосон хамтын ажиллагаанд онц ач холбогдол өгнө хэмээн бас хэлсэн. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Жеффри Фелтманы хэлснээр бол, бүс нутагт тогтвортой байдлыг хангах талаар ШХАБ-тай тогтоосон хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийн төлөө НҮБ ажиллана. Энд эдийн засгийн хамтын ажиллагаа гэхээсээ, бүс нутгийн цэрэг-стратегийн хамтын ажиллагааны асуудал яригдаж буй бололтой.

Нью-Йоркийн шинжлэх ухааны академийн гишүүн Геннадий Чуфрин гэдэг орос эрдэмтэн ШХАБ ба БРИКС-ийн ач холбогдлыг арай өөр өнцгөөс үнэлжээ¹⁶. Хөгжиж буй орнууд маш олон хөзөр гаргаа барьж тоглоно, гэхдээ л НАТО ба Европын Холбоо урьдын адил олон улсын тавцанд үлэмж үүрэгтэй байх болно, харин Азийн тэр байгууллагын дуу хоолойг эрхбиш анхаарч сонсох байх. ШХАБ-ыг өргөжүүлбэ хэмээн сүүлийн 10 жил ярилаа. Өргөжүүлэх хууль эрхийн нөхцөл нь хангалтгүй байлаа. Энэ удаа тэр бэрхшээлээ давчихвал Энэтхэг, Пакистан хоёрыг гишүүнээрээ авчих байх. Харин тэгж чадвал ШХАБ-ын хувьд асар том үйл явдал болно. Учир нь энэ байгууллагын анхны форматыг өөрчилчихөж байгаа нь тэр болно. Өмнө нь ШХАБ нь Орос ба Хятад гэсэн хоёр улс дээр үндсэндээ тулгуурлаж байсан бол одоо идэвхтэй хөгжиж буй Энэтхэг нэмэгдэнэ. Энэ бол чанарын том өөрчлөлт болно. ШХАБ-ын өмнөх саммит, түүний өмнөх саммитаас энэ удаагийнх ялгарах болов уу, учир нь байдал түгшүүртэй байна, лалын терроризм, радикал исламизм ШХАБ-ын бүх гишүүн

16. ШОС: Курс на расширение, geo-politica.info/07.06.2015

орнуудын эрх ашгийг хөндөж байна. Тэр утгаар Оросын удирдлага ШХАБ-ын дотоод хэрэгт гарцаагүй оролцож таарна хэмээн энэ орос эрдэмтэн тэмдэглээд өмнө нь элдэв мэдэгдэл зөндөө хийцгээж байсан боловч хэн нь ч эдийн засгийн салбарт ШХАБ үлэмж ажил хийлээ хэмээн зориглон хэлэхгүй байгаа, тэр утгаар эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр ШХАБ урагш ахихгүй гэжээ.

Ес. ШХАБ хөгжөөд байгаа бус уу?

ШХАБ үлэмж амжилттай хөгжин дэвшиж байна хэмээн үзэгсэд бол ОХУ-ын албан ёсны эрх баригчид юм. Ерөнхийлөгч Путин тэгж хэлснийг эшлэн энэ байгууллагыг магтсан албаны хүн бол ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавров юм. ШХАБ-ын үндсэн гишүүн 6 улсаас гадна түүний үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй улс орон 12 байгаа ажээ. Ажиглагч, яриа хэлэлцээний түнш гишүүн Афганистан, Энэтхэг, Иран, Монгол, Пакистан, Беларусь, Шри-Ланка нь тэр 12 улсынх нь магнайд жагсаж байна. С.Лавровын ярьснаар ШХАБ-ын Гадаад хэргийн сайд нарын уулзалтаар Уфад болох дээд хэмжээний уулзалтаас гаргах шийдвэрийг урьдчилан хэлэлцэн зөвлөмж гаргасан ба түүний дагуу ШХАБ нь шинэ гишүүддээ нээлттэй болж, шинэ гишүүнээр нэр дэвшигчдийг Энэтхэг, Пакистан, мөн Афганистан, Иран, бусад нь гээд дарааллаараа ярайж байгаа аж¹⁷. Тэрхүү зөвлөмжийн үг өгүүлбэрээс үзвэл, аюулгүй байдлын салбарт уламжлалт болон шинэ асуудал, шинэ аюул тулгарч, түүний эсрэг хамтран үр бүтээлтэй тэмцэх нь чухал болох ба Хятадын шинэ торгоны замын төсөлтэй ШХАБ-ыг Евразийн интеграцын хамтын ажиллагаанд холбож өгөх асуудал ч яригдах бололтой. Евразийн интеграцын хамрах цар хүрээ нь Төв Ази – Алс Дорнодын маршрутаар өрнөнө.

ШХАБ-ын хөгжилд томхон хувь нэмэр оруулах нэг улс тодорсон нь Беларусь байх ба “ШХАБ-ын баруун хонгил” болоход бэлэн байгаагаа зарлажээ. Энэ удаа Минскээс ШХАБ-ын зуучлагч байх тухай санал цууриатав¹⁸. Тус улсад ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров айлчилж, хэлэлцээ хийсний дараа Белоруссын Гадаад хэргийн сайд Владимир Макей гэнэт ийм мэдэгдэл хийсэн нь яриа хэлэлцээний

17. Путин: интерес к работе ШОС проявляют еще 12 стран, ria.ru/politics/2015/06/03/

18. Белоруссия готова стать, скажем так, западным коридором ШОС, regnum.ru/11/06/2015/

Хүчний бодит тэнцвэрийг тогтоолгохоор ШХАБ, БРИКС-ийг нэг дор цуглуулна

түнш гишүүн энэ улсын статусыг дээшлүүлж ажиглагч болгохын илэрхийлэл болсон аж. Гишүүний статус дээшилж байгаа тул тус улсын Төрийн тэргүүн Александр Лукашенко Уфад очиж, БРИКС ба ШХАБ-ын удирдагчдын уулзалтад оролцоно хэмээн зарлажээ. Беларусь нь БРИКС-ийн хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцохоо илэрхийлж, ялангуяа Хөгжлийн шинэ банктай хамтран ажиллахыг онцгой сонирхоно хэмээн В.Макей ярьжээ.

Арав. Афганыг гишүүн болгож бөөн гай өөр дээрээ дуудах эрсдэл

Уфагийн уулзалтаар гэнэт шийдвэрлэгдэж мэдэх гишүүнчлэлийн эгзэгтэй өөр нэг асуудал нээлттэй байна. Экстремизм, сепаратизмтай тэмцэх талаар Афганистан, ШХАБ-ын хоорондын харилцан ажиллагааны протоколд 2015 оны 5 дугаар сард Кабулд гарын үсэг зурсан. Мөн энэ улсыг ШХАБ-д жинхлүүлэх асуудал ярилцсан. Эдүгээ бүтэн сар гаран Афган даяар энэ сэдвээр хэлэлцүүлэг өрнөж буй гээд хэлчихэд хэтрүүлэг болохгүй. Энэ байгууллагад бүрэн эрхт гишүүн болсноор Афганистаны эрх ашигт яг нийцнэ, хэрэв өрнөд дэх түншүүд нь саад хийхгүй бол Кабул элсэхэд бэлэн байна, эдийн засгийн талаасаа бол их хожно хэмээн афганы өөрийнх нь эрдэмтэд үзэж байна. ШХАБ гэдгийг Афганистан улс эдийн засгийн өнцгөөс харж байна¹⁹. Яваандаа тус улс бүс нутгийн чухал зангилаа нэг улс болж болно, тэгснээрээ аюулгүй байдал тогтвортой байлын үйлсэд их хувь нэмэр оруулна. Бүр ШХАБ-ын гишүүн ихэнхи орнуудын хувьд гүүр болж болно. Учир транзитын ач холбогдол тун их билээ хэмээн тэр сайтад бичсэн байх аж. Афганистаны Худалдааны сайд асан Мохаммад Амин Фархан гэдэг хүний ярьснаар бол, Афган ба ШХАБ-ын хоорондын интеграц хэзээ мөдгүй эхлэх ба тэгж эхэлснээр энэ орныг анхаарах шохоорхох явдал дэлхийд шинэ шатанд гарах гэнэ.

Эдийн засгийн талаасаа бус Афган-Пакистаны бүс нутгийн 2015 оны геополитикийн хувьсал л энэ орныг ШХАБ руу чиглүүлнэ хэмээн эрдэмтэн Салман Шейх үзсэн байна²⁰. Учир нь шинэ Ерөнхийлөгчийн өнгөн дээр Кабул нь Исламабад руу огцом эргэсэн ба Талибан

19. China- and Russia-led Shanghai bloc eyes Afghan role, wadsam.com/afghan business news portal/06 June 2015

20. Salman Rafi Sheikh. Afghanistan: BSA Prolongs the Longest War in US history, journal-neo.org/2015/02/21/

хөдөлгөөнийг номхруулах тал дээр өмнөд хөрш Пакистанаа түших болсноор ШХАБ руу аяндаа хандахаас аргагүй болно. Учир нь Энэтхэгтэй зэрэгцүүлээд түүний өрсөлдөгч Пакистаныг ШХАБ-д жинхлүүлж байгаа бол Пакистаны тал баримталсан Ерөнхийлөгч Ашраф Гани Ахмадзай нь Пакистаны араас зуурсаар байгаад ШХАБ руу орохоос аргагүй болох аж. Өрнөдийг баримжаалсан өмнөх Ерөнхийлөгчийн өнгөн дээр Талибантай арван хэдэн жил байлдаад дийлсэнгүй, харин энэ удаа ШХАБ-д элсээд геоэдийн засгийн лут төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлээд геополитикийн ялалтыг хангана гэж үзэх ажээ. Шинэ Ерөнхийлөгч Ахмадзай бол бүс нутгийн ойрын тоглогчид болох Пакистан, Хятад, Энэтхэг, Ирантайгаа харилцаагаа хөгжүүлэхийг зоригч, НАТО-гийн ISAF (International Security Assistance Force) хэмээх олон улсын энхийг сахиулах хүчнийг гаргаж дууссаны дараахи бодит аюулыг мэдрэгч хүний хувьд “Пакистан ба ШХАБ” гэсэн гадаад бодлогын шинэ чиглэл гаргаж ирж байх шиг.

Геополитикийн хүчтэй өрсөлдөөний талбар болж ирсэн Афганистаныг ШХАБ-д жинхлүүлснээр тэр өрсөлдөөний эрч суларна, тэр утгаараа тогтвортой байдал дээрдэнэ хэмээн афган эрдэмтэд хэлж ярьж байгааг ор тас үгүйсгэмгүй.

Тэдний тайлбар ч ойлгомжтой юм. Өмнө нь цэргийн хүчээр энхийг тогтоож байсан ISAF-ыг бодохул ШХАБ нь Афганистаны байдалд шал өөрөөр нөлөөлнө гэж үзэж байна. 1997 оны Орос-Хятадын Москвагийн тунхаглал (Олон туйлт ертөнцийн тухай), 2001 оны ОХУ, БНХАУ-ын гэрээ гэхчлэн тулгуур баримт бичгүүдэд бүс нутгийн аюулгүй байдлыг дэмжин сахиулах системийг зааж өгснийг афганчууд гэнэт уухайлан эшлэх болжээ. Ардчиллыг өргөжүүлэн, дэглэмүүдийг солих замаар аюулгүй байдал тогтоодог америкийн концепц Афганистанд хэрэгжсэнгүй, “Арабын хавар”-ын дараахи Арабын орнуудад бүр ч хэрэгжсэнгүй тул ШХАБ руу хандахаас аргагүй гэх дүгнэлт хийсэн нь анхаарал татлаа²¹.

Дээрхи бичсэнээс ажиглалт хийж үзэхэд, АНУ, НАТО-гийн хүчнийг гаргасны дараахи Афганистаны аюулгүй байдлын том ангалыг ШХАБ-аар нөхүүлэх, хамаг ачааг үүрүүлэх далдын

21. How Close can Afghanistan and Pakistan Get in 2015? journal-neo.org/2015/06/17

төлөвлөгөө явж байж магадгүй юм. Хэрэв Афганистан ба ШХАБ-ын хооронд жинхэнэ интеграц хөгжүүлэх бол эхлээд Талибаныг энэ улсын нийгмийн амьдралаас бүрмөсөн устгаж арилгах ёстой, хар тамхины тариалалт ургацаараа ДНБ-ээ бараг тэр чигт босгож буй эдийн засгийн тогтолцоогоо орвонгоор нь өөрчлөх ёстой. Тэр бүхнийг ШХАБ хийхээр очлоо гэж үү?

Арваннэг. Дахиад л нөхвөр

Орос ба Өрнөдийнхний өвөр хоорондын харилцаа ноцтойгоор муудсан, Орос нь улс төр, эдийн засгийн изоляцад орсон нөхцөлд Уфагийн энэ удаагийн дээд хэмжээний хоёр уулзалт давхцана. Ази, Латин Америкийн орнуудтай тогтоосон харилцаа Орост нэн чухал ач холбогдолтой болж байгааг БРИКС, ШХАБ-ын уулзалтууд нотлоно. Москва нь Азийн гигантууд руу ухралтгүйгээр эргэлээ. Тэд нь олон улсын харилцаанд тэгш эрхийг хүсэмжилдэг учраас Оросын жин нөлөөг бэхжүүлнэ, худалдаа-эдийн засгийн шинэ боломж гаргаж өгнө хэмээн үзэж болох юм.

Хоёр том төслийг холбож уялдуулах тал дээр эдүгээ ШХАБ идэвхтэй ажиллаж байна. Тэр хоёр төсөл нь Торгоны замын эдийн засгийн бүс, ЕАЭС юм. ЕАЭС-ыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейд ажиглагч олон улсын байгууллагаар элсүүлэх талаар энэ намраас ОХУ, Беларусь хоёр ажиллана гэдгээ зарлачихлаа. ЕАЭС ба Торгоны замын эдийн засгийн бүсийн хооронд холбогч гүүрийн маягтай ажиллана гэдгээ ч В.Путин ШХАБ-ын Гадаад хэргийн сайд нарын зөвлөлийн хуралдаан дээр мэдэгдчихсэн. Өөрөөр хэлбэл бүс нутгийн олон улсын гурван форум, үйл явц угталцан нэг цул эвсэл үүсэх болох нээ. БРИКС-ийг ч үүн дээр нэмэх тухай яригдах нь гарцаагүй. Зургадугаар сарын 8-нд Москвад БРИКС-ийн парламент хоорондын анхдугаар форум болж, хууль тогтоох байгууллагуудын дарга нараа уулзуулсан бол сарын дараа төр, засгийн тэргүүн нар Уфад цугларна.

БРИКС-ийн өмнөх даргалагч Бразилаас даргалагчийн дараагийн үүрэг ОХУ-д шилжиж ирмэгц улс төрийн нөлөө бүхий клуб болохыг нь дэлхий нийт таньж мэдэх учиртай хэмээн оросын тал үзэж байна. Сири, Ирак, Украин, палестины асуудал, Африк дахь мөргөлдөөнүүдийн

талаар талууд байр сууриа тохиролцсон хэмээн өнгөрсөн онд Бразилд (Форталез) болсон дээд хэмжээний уулзалтын баримт бичигт байгаа ч яг үгссэн, хөдлөшгүй тогтсон нь юу л бол, учир нь Украины хямралын асуудлаар Орос БРИКС-ийн гишүүн улсуудаасаа дэмжлэг авч чадаагүй л байгаа.

Бразилын Ерөнхийлөгч хатагтай Дилма Руссефф энэ 5 улсын клубыг хөгжүүлэх талаар сулхан ажилласан гэх шүүмжлэл оросын сайтуудад явж байна. Оросын санал болгосон хоёр чухал баримт бичиг хэрэгжилгүйгээр даргалагч Орос руу шилжиж байна. Тухайлбал БРИКС-ийн хүрэн дэх олон талт эдийн засгийн хамтын ажиллагааны стратеги, Хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны замын зураг гэх хоёр төсөл байна. Хөрөнгө оруулалт гэдэг нь янз бүрийн салбарыг хамрах тодорхой 37 төсөл аж. Тэдгээр дотор БРИКС-ийн Эрчим хүчний ассоциац буй болгох, түүнд түшиглэн Нөөцийн банк байгуулах, Эрчим хүчний бодлогын институт байгуулах явдал байв. Хэрэгжүүлэх алхам хийгдээгүй эдгээр төсөл Уфагийн уулзалтаар буурьтайхан хэлэлцэгдэж магадгүй.

БРИКС ба ШХАБ-ыг ОХУ даргалах болсноор үйл ажиллагааных нь хүрээ тэлэх, энэ хоёр форум нь институционал нэгдэл болж шат ахих магадлал өндөр байж болно. ОХУ БРИКС-ийг даргалахдаа этгээд, өвөрмөц шийдвэр олныг гаргаж ирж түншүүдээ алмайруулахыг үгүйсгэхгүй. Учир нь ОХУ нь өрсөлдөгчид, дайснуудынхаа хий гишгэгдэл бүхнийг анаж байгаа. Грекийн хямралаас болж Европын Холбоо суларвал тэр боломжийг алдахгүй гэдгээ илтгээд авлаа. 2015 оны 7 дугаар сарын 5-нд Грект референдум явагдаж, оролцогчдынх нь 61.31 хувь Европын Холбооны зээлдүүлэгчдийн хөтөлбөрийн эсрэг санал өгмөгц Орос шүүрэн авч, Грекийг БРИКС-т элсүүлэх төсөл гэдгээ гэнэт гаргаж тавилаа. Энэ тухай БРИКС-ийн бизнесийн зөвлөлийн оросын хэсгийн дарга, ХАҮТ-ын ерөнхийлөгч Сергей Катырин төр-засгаа төлөөлөн мэдэгдэл хийжээ. Грек өөрөө хүсвэл БРИКС нээлттэй. БРИК анх байгуулагдахдаа Өмнөд Африкгүй эхлээд болж л байсан, дараа ӨАБНУ нэгдсэн шүү дээ²² хэмээн тэрээр ярьжээ. Грек нь Европын Холбооны хуучин уламжлалт гишүүн, евробүсийн

22. Глава ТПП: Греция может присоединиться к БРИКС, только став “быстрорастущей экономикой”, tass.ru/ekonomika/2097206

орон байгаа нь оросуудад төдийлөн хамаатай бус, Европын Холбооны өмнө авсан Грекийн үүрэг амлалт хөсөрдвөл харин ч сайн гэх аястай. Эдүгээ энэ улсын өр 300 тэрбум еврогоос давсан ба олон улсын зээлдүүлэгчидтэй хэл амаа ололцох гэж зовлон туулж байгаа²³. Эдийн засгийн хатуу чанга бодлого явуулж баймааж нь хариуд нь Европын Төв Банк, ОУВС, Европын Комиссын санхүүгийн дэмжлэг хүртэх болж байгаа нөхцөлд тэр нөхцлүүдийг үл хэрэгсээд БРИКС рүү хандаасай гэх нь Оросын геополитикийн аргагүй байр суурь байж болно.

Өсөн нэмэгдэж буй эдийн засгийн нөлөөгөөрөө G7-г сэргүүлсэн БРИКС бүлгийн жил тутмын VII саммит руу Грекийн Ерөнхий сайд Алексис Ципрас хандаж магад, учир нь тэрээр Москва–Бээжингийн тэнхлэгт үндэслэсэн дэлхийн шинэ дэг журмыг өөртөө нээж болох юм гэсэн санаагаар Марк Маккиннон гэдэг өрнөдийн судлаач бичсэн²⁴ нь Оросын дээрхи санал өргүй хоосон мөрөөдөл бишийг илтгэх мэт. Харин энэ М.Маккиннон нь ШХАБ-ыг НАТО-г сэргүүлсэн цэргийн эвсэл хэмээн нэрлэсэн анхаарал татахаар юм. БРИКС-ийн хөгжлийн шинэ банк гэдэгт элсэж орох боломжийг Грекийн Засгийн газар судалж үзнэ хэмээн Ципрас мэдэгдсэн нь ч шинэлэг үзэгдэл боллоо.

БРИКС нь 5 улс оролцсон улс төрийн клуб, шийдвэрээ консенсусын үндсэн дээр гаргадаг байсан бол Орос нь олон улсад манлайлагч явсан хур туршлагатайн хувьд тогтсон уламжлалыг ямар ч хэлбэрээр өөрчилж болох юм. Тэр нь институцчилах чиглэлээр хийгдэх эхний алхамууд байж болно. Санхүүгийн институцчиллыг бусад гишүүддээ тулгаж магадгүй. БРИКС-ийн Хөгжлийн банк гэдгийг одоо л жинхэнэ ёсоор амилуулж магадгүй. Эдийн засгийн гадаад харилцааг уриа тунхагаас нь гаргаж, бодитой хэрэгжүүлэхээр Орос улайрах нь гарцаагүй. Хөрөнгө оруулалтыг Орос шаардана. Учир нь Украины хямралаас шалтгаалан эдийн засгийн хориг тавиулж, гаднаас орж ирдэг мөнгөө царцаалгаж, хямралд автаад байгаа. Тиймээс БРИКС-ээс нөхвөр хэрэгтэй. Хятадад үлэмж ачаа үрүүлэхээр санал болгож магадгүй юм.

Хятад бол дэлхийн гол хөрөнгө оруулагч болчихоод байна. 2014 онд БНХАУ нь дэлхийн 156 орны эдийн засагт хөрөнгө оруулалт хийсэн ба

23. Европын статистикийн мэдээгээр 2014 онд Грек нь 2009 оноос хойш анх удаа ДНБ-ий 0.8 хувийн өсөлттэй гарсан ба тус орны ДНБ бүхэлдээ 179.08 тэрбум евро болох ажээ.

24. Tsipras could find a new world order built on Moscow-Beijing axis, theglobeandmail.com/Wednesday, Jul. 08, 2015

тэр нь 6000 гаран төсөлд орсон. Орос нь хятадын хөрөнгө оруулалтыг гадагчдын дотор 6 дугаарт бичигдсэн²⁵. Тэгвэл энэ удаа БРИКС, ШХАБ-ыг нэгэн зэрэг урьснаараа Москва хөрөнгө оруулалтын сацуу үндэсний валютаар харилцан төлбөр тооцоо хийх, нисэх онгоцны аж үйлдвэр, төмөрлөг, суурь машины аж үйлдвэр, эмийн үйлдвэр, уул уурхайн олборлолт, боловсруулалт зэрэг тодорхой салбарууд дээр ярьж магадгүй байна. Олон улсын мэдээллийн аюулгүй байдал гэсэн шинэ асуудал лав БРИКС-ийн уулзалтаар яригдана. Гишүүн орнуудын хөдөлгөөнт мобил операцын систем буй болгох асуудлыг тавих нь байна.

ДҮГНЭЛТ

БРИКС, ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтыг нэгэн цагт, нэг газарт Орос зохион байгуулж байгаа энэ цаг үе өөрөө олон улсын харилцааны үлэмж хямралтай, “Шинэ Хүйтэн дайн” дэгдэж буй цаг үед болж байгаагаараа гол онцлогтой юм. Орос өөрөө ийм хүнд цаг үед, дотооддоо хямралтай, олон улсын нэр хүнд нь унасан ийм цаг үед дэлхийн гурван тивийн арван хэдэн улсын төр, засгийн тэргүүнүүд Уфаг зорьж байгаа нь өөрөө парадокс үзэгдэл юм. Энэ бүхэн ганцхан хүчин зүйлээс улбаатай. Тэр нь Орос-Америкийн сөргөлдөөн. Энэ сөргөлдөөнд НҮБ, олон улсын бусад байгууллага, G20 (хөгжингүй 20 улсын бүлэг), бүр Арктикийн зөвлөл (Хойд мөсөн далайн орнуудын зөвлөл) хүртэл золиос болсон үед тэд Уфад цугларцгааж байна.

Дэлхийн хамтын нийгэмлэгт тэгш эрхт түнш нь Орос байж чадахгүй дүр зураг харагдаж байгаа бол тэр алдагдлыг Орос хэрхэн юугаар нөхвөрлөх вэ? Үүнд геополитикийн хэрэгсэл болж Оросын нүднээ буух нь илт болж буй бүс нутгийн эвслүүдийг зэрэгцүүлэн хөгжүүлж, өрсөлдүүлж, улмаар нэгтгэх замаар Евразиас АНУ, түүний холбоотнуудын ашиг сонирхлыг шахаж гаргахыг зорин тэмүүлэх болно. Евразийн геополитикийн архитектурт өмнө нь өрнөдийн гүрнүүд давамгайлж байсан бол одоо тэгдэг цаг өнгөрлөө гэдгийг нотлон харуулах Оросын хувьд нэн чухал.

Үүнд “Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага+Евразийн эдийн засгийн холбоо+Торгоны зам” гэх шинэ тэнхлэг үүсэх магадлалтай. Үүнд Шанхайн байгууллагыг гол холбогч үүрэгтэйгээр Евразийн

25. Москва делает ставку на БРИКС, jenkers.com/08.06.2015

гүүр болгох ба тэнхлэгийн умард ба баруун хэсэгт Евразийн холбоо, тэнхлэгийн өмнөд ба дорнод хэсэгт Торгоны замын эдийн засгийн бүс байх, холбогч нь ШХАБ байх бүтцийг Орос мөрөөдөж байна.

Харин АНУ-ыг Евразиас шахаж гаргана гэдэг дээр Хятад хөндөлдөдөггүй юм аа гэхэд, лав хөхиүлэн дэмжихгүй. Орос-Америкийн хоорондын шинэ “Хүйтэн дайн”-ыг Хятад хүсэхгүй, өөгшүүлэхгүй, Оросын талд баттай зогсохгүй гэж үзэж болох юм. Орос, Хятад, БРИКС, ШХАБ хүссэн, эс хүссэн ч АНУ өнөөдөр дэлхийн эдийн засгийн мотор, олон улсын арбитр хэвээрээ байна.

Энэ цаг үеийн хамгийн гол онцлог бол бид стратегийн туйлын тодорхой биш цаг үед тулж ирээд байна. Олон улсын харилцаанд хаашаа л харнав, тодорхой юм алга. Бүгд л шилжилт хөдөлгөөндөө байх шиг. Тэр утгаар олон улсын байгууллага, форум, үйл явцууд мөн шилжилт хөдөлгөөний үедээ байна.

Энэ удаагийн БРИКС, ШХАБ-ын даргалагч улс ОХУ-ын хувьд Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага+Евразийн эдийн засгийн холбоо+Торгоны зам” гэх шинэ тэнхлэгийг хүсч байгаа шигээ Уфагийн саммитаас өөр нэг тэнхлэгийг санаачилж болох юм.

БРИКС, ШХАБ нь сайн сайхан, бүрэн төлөвшсөн, нийтийн тохиролцоонд бүрэн хүрсэн форум биш учраас эдгээрийг Орос нь улс төр-эдийн засгийн элдэв санкц, Евразийн хонгил гарц, ялангуяа ШХАБ-ыг хар тамхины зөөврийн сүлжээ, экологийн миграц, Афганистанд байдал хурцдахаас үүсэх бүх нийтэд учрах аюул, “Лалын улс”-ын хүчин зүйл, радикал исламизмын аюул занал гээд аюулгүй байдлын элдэв асуудалтай холбочихож болох юм.

Ачааны хүндийг үүрэх үүрэг ирж буй Хятад нь Шинжаан-Уйгурын өөрөө засах орондоо лалынхны сепаратист тэмцэлтэй нүүр тулж байгаа ба тэр нь Төв Ази, Орос, Монголтой хил залгаа бүс нутагт сөргөөр нөлөөлөх магадлал буй. Тэгэхлээр энд Орос, Хятад, Торгоны замын эдийн засгийн бүс дайрч өнгөрөх бүх улс нийтээрээ ОДКБ, ШХАБ гэх механизмыг ашиглах ёстой хэмээн оросууд үзэж байна. Цэрэг-аюулгүй байдлын шугамаар хил дамнасан төсөл хэрэгжүүлэх цаг дөхөж буй аж. Ийм л дэвсгэр дээр Уфад уулзацгаах боллоо.